



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



ШУТИС-ИЙН БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР “FACULTY DEVELOPMENT SUPPORT” PROGRAM

**УЛААНБААТАР ХОТ
2019 он**

fdc@must.edu.mn

a.sunjidmaa@must.edu.mn хаягаар саналаа ирүүлнэ үү.

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Эрх зүйн үндэслэл
- 1.2 Хамрах хүрээ
- 1.3 Хөтөлбөрийн тодорхойлолт, зарчим

ХОЁР . ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- 2.1 Хөтөлбөрийн зорилго
- 2.2 Хөтөлбөрийн зорилт
- 2.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

- 3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө
- 3.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 3.3 Хөтөлбөрийн хүрэх үр дүн

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ

- 4.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт
- 4.2 Хөтөлбөрийн үнэлгээ

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

- 5.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт
- 5.2 Хөтөлбөрийн санхүүжилт

ХАВСРАЛТ

ӨМНӨХ ҮГ

Хөгжлийн төлөө хүний нэн тэргүүний хэрэгцээ нь мэдлэг ба хүний хөгжлийн үндсэн хүчин зүйл, сайн сайхан амьдралын эх сурвалж болох боловсрол юм. Боловсрол хэмээх гайхамшигт ертөнцийн тэргүүн хойморт, нарт ертөнцөд эгнэшгүй нандин сайхан мэргэжилтэй багши хүн гол байр суурь эзэлдэг.

Дэлхийн олон улс орон шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлан дэвшилтэт болон өндөр технологийг нэвтрүүлэх замаар улс үндэстнүүдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд хөгжлийн бодлогоо чиглүүлэн их сургуулийн багшийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарал хандуулж байна.

Их сургууль хөгжин дэвжих, хүчирхэг байхын үндэс нь багшийг хэрхэн хөгжүүлснээс шалтгаалдаг тул тэднийг урамшуулан дэмжих, хөгжлийн бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх, ажлаас төрөх сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, сургалтын орчныг сайжруулахад анхаарч тасралтгүй хөгжих эрмэлзлийг бий болгох замаар гарцаа тодорхойлж байна.

Өнөөдөр их сургуулийн багш нь насан туршид уйгагүй суралцаж боловсролын чанарын бодлоготой уялдан стандартын шаардлагад нийцэж, олон улсад өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэн ажиллах үүрэгтэй юм.

ШУТИС-ийн хөгжлийн тулгуур болсон “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” нь ШУТИС-ийн стратегийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлж, сургалт-судалгааны олон талт арга зүйг эзэмшсэн, багшийн ёс зүй, эрдэм судлалыг дээдэлсэн бүтээлч багшийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ЭРХЭМ БАЯН-ЭРДЭМ УХААН ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ

РЕКТОР

Б.Очирбат

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Энэхүү хөтөлбөр нь Азийн тэргүүлэх их сургуулийн нэг болох ШУТИС-ийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

- 1.1 **Эрх зүйн үндэслэл.** “ Их, дээд сургуулиудын багшлах боловсон хүчний статусын тухай зөвлөмж” ЮНЕСКО /1997/, “ Багшийн хөгжлийг дэмжих тухай” Монгол улсын хууль /2018/, “ Монгол улсын урт хугацааны тогвортой хөгжлийн үзэл баримтлал” /2016- 2030/, “ Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” /2014-2024/, “ Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” /2018/, “ ШУТИС-ийн Хөгжлийн стратегийн замын зураглал” /2012-2021/ MUST-2021, Roadmap зэрэг нь энэхүү хөтөлбөрийн эрх зүйн үндэслэл болно.
- 1.2 **Хамрах хүрээ.** Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт ШУТИС-ийн албан тушаалын ангилалын дагуу ажиллаж буй нийт багш нар хамрагдана.
- 1.3 **Хөтөлбөрийн тодорхойлолт, зарчим.** Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь мэдлэгийг инноваци, технологи, бүтээгдэхүүн болгох, олон улсад өрсөлдөх чадвартай багшийг тасралтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

- ❖ Багшийн хөгжлийн тогтолцоог сургуулийн бодлогоор тасралтгүй, тогтвортой дэмжих
- ❖ Багшийг хөгжүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахдаа шударга, ил тод байдал, нээлттэй байх зарчмыг баримтлан хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах,
- ❖ Их сургуулийн удирдлага, бүрэлдэхүүн сургууль, тэнхим, багшийн хамтын ажиллагааг уялдуулан хөгжүүлэхэд чиглэсэн байх

Багш бүр хөгжлийн төлөвлөгөө гарган батлуулж, үр дүнг хичээлийн жилийн эцэст салбар, тэнхимийн эрхлэгчээр үнэлүүлж, дараагийн төлөвлөгөөг гарах замаар хөтөлбөрийн хэрэгжилтэнд оролцоно

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1 Хөтөлбөрийн зорилго. ШУТИС-ийн алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн стратегид тулгуурлан судлаач, багш бүрийн мэдлэг, чадварыг тогтвортой хөгжүүлэх их сургуулийн хөгжилд багшийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

- | | |
|------------|---|
| Зорилт -1 | Багшийн сургахуйн ур чадварыг дээшлүүлэх |
| Зорилт- 2 | Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх |
| Зорилт -3 | Багш- хувь хүний хөгжлийг дэмжих |
| Зорилт - 4 | Санхүү- нийгмийн түншлэлийг өргөжүүлэх |

2.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Энэхүү хөтөлбөрийг 2019-2030 онуудад 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ

- Нэгдүгээр үе шат: 2019-2022 оны хичээлийн жил
- Хоёрдугаар үе шат: 2023-2025 оны хичээлийн жил
- Гуравдугаар үе шат: 2026-2030 оны хичээлийн жил

Үе шат тус бүр ажлын төлөвлөгөөтэй байх ба хэрэгжүүлэх хугацаанд хийх үйл ажиллагаа, хүрэх үр дүнг тусгасан байна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХҮРЭХ ҮР ДҮН

3.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Хүрэх үр дүн	Хугацаа
1	Багшийн сургахуйн үр чадварыг дээшлүүлэх	<p>_ Сургалтын технологи, арга зүйн мэдлэг, үр чадварыг шинэ шатанд гаргахад чиглэсэн модуль сургалт зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, зөвлөн чиглүүлэх үйлчилгээ үзүүлэх</p> <p>_ Сургах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, шинэлэг арга зүйгээр зохион байгуулах олон улсын дэвшилтэт, сайн туршлагыг нэвтрүүлэх</p> <p>_ Багш нарын англи хэлний мэдлэг, чадварыг сайжруулах, англи хэлээр хичээл заах чадвартай багш нарыг бэлтгэх</p>	<p>_ Сургалтын чанар сайжирч багшийн заах арга зүйн үр чадвар дээшилнэ</p> <p>_ Олон улсын дэвшилтэт, сайн туршлагыг нэвтрүүлснээр мэдлэгийг бүтээгч хөрвөх чадвартай мэргэжилтэнг бэлтгэн гаргана</p> <p>_ Орчин үеийн нээлттэй боловсролын чиг хандлагад нийцсэн насан туршид өөрийгөө хөгжүүлэх чадвартай багш болно.</p> <p>_ Багш нарын англи хэлний мэдлэг, чадварыг сайжруулах, англи хэлээр хичээл заах чадвартай багш нарыг бэлтгэх</p>	2019-2021 хичээлийн жил
2	Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	<p>_ Багш бүр суурь ба хавсарга судалгааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хөгжлийн хөтөлбөр боловсруулах</p> <p>_ Эрдэм шинжилгээний хурал, семинар, арга зүйн сургалт зохион байгуулах, оролцох</p> <p>_ Эрдэм шинжилгээний бүтээлийн чанарыг сайжруулах, хэвлэн нийтлэх үйл ажиллагааг тогтмолжуулах</p> <p>_ Инновацийг хөгжүүлэх, шинэ мэдлэг бүтээх, суурь судалгааны ажлыг эрчимтэй явуулах</p> <p>_ Эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааны чанарын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах.</p>	<p>_ Багш бүрийн судалгааны тэргүүлэх чиглэлүүд тодорхойлогдсон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хөгжлийн хөтөлбөртэй байна</p> <p>_ Эрдэм шинжилгээний хурал, семинар, арга зүйн сургалт зохион байгуулах, оролцох үйл ажиллагаа тогтвортой болно</p> <p>_ Эрдэм шинжилгээний бүтээлийг эргэлтэд оруулах үйл ажиллагаа тогтмол болно</p> <p>_ Шинэ мэдлэг, инновацийг эрдэм шинжилгээний болон эдийн засгийн эргэлтэд оруулна</p> <p>_ Эрдэм шинжилгээ, судалгаа хийж гүйцэтгэх үйл ажиллагааг тоон болон чанарын талаас хэмжих боломж бий болно.</p>	2019-2025 хичээлийн жил

3	Багш- хувь хүний хөгжлийг дэмжих	<p>_Багш хичээл заах, хамтарсан, салбар дундын, эрдэм шинжилгээний ажил хэрэгжүүлэх, олон улсын түвшний зэргийн болон зэргийн бус хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэжлийн англи хэлний мэдлэг, чадвар, арга зүйг сайжруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх</p> <p>Багшийн хувь хүний ёс зүй, манлайлал болон хувь хүний хөрвөх чадварыг хөгжүүлэх</p>	<p>_TOEFL, IELTS –ийн шалгалтанд өндөр оноо авсан багш нарын тоо өсч, шинжлэх ухааны болон мэргэжлийн түвшинд хүлээн зөвшөөрөгдөнө.</p> <p>_Багшийн мэргэжлийн болон хувийн ур чадвар дээшилж, аливаа асуудалд хариуцлагатай ханддаг болж өөрийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх чадвартай болно</p>	2019-2023 хичээлийн жил
4	Санхүү- нийгмийн түншлэлийг өргөжүүлэх	<p>_Өрсөлдөх чадвартай шилдэг багш, судлаачдыг урамшуулж дэмжлэг үзүүлэх</p> <p>_Багш бүрийн тасралтгүй хөгжих боломж нөхцлийг бүрдүүлэх, бодлого, санхүүгээр дэмжих</p> <p>_Нийгмийн түншлэлийг өргөжүүлэн эрдэмтэн багш судлаачдын мэргэжил дээшлүүлэх үр дүнтэй хэлбэр, арга замыг эрэлхийлэн хэрэгжүүлэх замаар мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэх</p>	<p>_Олон улс ба үндэсний хэмжээнд өрсөлдөх чадвартай багш нарын тоо нэмэгдэнэ</p> <p>_Багш бүрийн тасралтгүй хөгжих боломж нөхцлийг бүрдүүлж үр дүнд тулгуурлан уян хатан урамшууллын тогтолцоо бий болно</p> <p>Багшийн салбар дундын судалгаа, олон улсын түвшний хамтарсан судалгаа хөгжлийн менежмент хийх, эрдэм шинжилгээний хурал, форум зохион байгуулах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн хамтарсан төсөл, хөтөлбөр, санаачилга хэрэгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлнэ</p>	2019-2025 хичээлийн жил

3.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр нь багшийн албан тушаалын зэрэглэлд тавигдах шаардлага, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, 4 үндсэн зорилтын хүрээнд тодорхойлогдох ба дараах үндсэн 5 модулиар сургалтын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна:

1. Багшийн сурган, заах арга зүй, мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх;
2. Эрдэм шинжилгээ, судалгааны чадамжийг дээшлүүлэх ;
3. Багшийн англи хэлний чадамжийг үе шаттай, системтэйгээр дээшлүүлэх;
4. Мэдээлэл, холбооны технологийг сургалтад хэрэглэх чадамжийг дээшлүүлэх;
5. Багшийн үнэлгээ, урамшууллын системийг хэрэгжүүлэх

3.3 Хөтөлбөрийн хүрэх үр дүн

Монгол Улсын Төрөөс боловсролын талаар баримтлах үзэл баримтлалыг үндэслэн өндөр мэдлэг, боловсрол, чадвартай багшийг хөгжүүлж ажиллана.

Сургалтын шинэ технологи, арга барилуудыг нэвтрүүлж хөрвөх чадвартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх, нийт сургалтын хөтөлбөрийн 30 хувийг англи хэл болон зайн хэлбэрээр явуулна.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ

4.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт
Зорилт_1 Багшийн сургахуйн ур чадварыг дээшлүүлэх	
1	Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлэх
2	Багшлах арга зүйг дээшлүүлэх шаталсан сургалтад хамрагдах
3	Сургалтад мэдээлэл харилцааны технологи ашиглах
4	Англи хэл дээр хичээл заах арга зүйг дээшлүүлэх
5	Хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулах
Зорилт_2 Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	
1	Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр үнэлгээний индекс өндөртэй олон улсын мэргэжлийн сэтгүүд өгүүлэл хэвлүүлэх
2	Олон улсын хэмжээнд бүтээлээс нь ишлэл татагдсан байдал <i>Өндөр үнэлгээтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо</i> <i>Ишлэл авсан өгүүллийн тоо</i>
3	Патент, Зохиогчийн эрх, Ашигтай загварын тоо
4	Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр их сургуульд оруулсан хувь нэмэр
Зорилт_3 Багш- хувь хүний хөгжлийг дэмжих	
1	Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх
2	Зөвлөх, мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдах
3	Судалгааны арга зүйг хөгжүүлж, эрдмийн зэрэг хамгаалах , Эрдмийн цол хүртэх
4	Англи хэл дээр мэргэжлийн ном, сурах бичиг бэлтгэх анхан, дунд, ахисан түвшний сургалт явуулах/ хамрагдах/
5	Багшийн ёс зүй, мэргэжлийн ёс зүйн сургалтуудад хамрагдах
6	Хамтран ажилладаг багийн үнэлгээ
Зорилт_4 Санхүү- нийгмийн түншлэлийг өргөжүүлэх	
1	Мэргэжлийн нийгэмлэг, байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, Аж үйлдвэр, бизнес, үйлдвэрийн захиалгат болон гэрээт судалгааны тоо
2	Ажил олгогчидтой хамтарсан хурал, зөвлөгөөн зохион байгуулах
3	Их сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт

4	Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлсэнээр сургуульд оруулсан орлогын хэмжээ
5	Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг дотоод, гадаадын мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх

4.2 Хөтөлбөрийн үнэлгээ

Хөтөлбөрийн үнэлгээг нийт 5 түвшинд хөтөлбөрийн төлөвлөгөөний гүйцэтгэлээр үнэлэх бөгөөд үнэлгээнд оролцогч талууд тэгш эрхтэй оролцоно.

Д/д	Үнэлгээ/Зорилт	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4
1	Өөрийн үнэлгээ	100%:0%	50%:50%	50%:50%	0%:100%
2	Салбар, тэнхим	100%:0%	50%:50%	50%:50%	0%:100%
3	Бүрэлдэхүүн сургууль	100%:0%	50%:50%	50%:50%	0%:100%
4	Захиргааны нэгж	100%:0%	50%:50%	50%:50%	0%:100%
5	ШУТИС-ийн захирал	100%:0%	50%:50%	50%:50%	0%:100%

Өөрийн үнэлгээ:

$$A_1 = ((100\%;0\%) + (50\%;50\%) + (50\%;50\%) + (0\%;100\%)) = 100\%$$

$$A_i = \frac{(A_{i-1,i-1} + A_{ii})}{4} = 100\%, \quad i = 2,5$$

A_{11} - өөрийн үнэлгээ:


$$A_{11} = \frac{(Objec\ 1(100\%)) + (Objec\ 2(50\%)) + (Objec\ 3(50\%)) + (Objec\ 4(0\%))}{2} = 100\%$$

A_{ii} - удирдлагын үнэлгээ:

$$A_{ii} = \frac{(Objec\ 1(0\%)) + (Objec\ 2(50\%)) + (Objec\ 3(50\%)) + (Objec\ 4(100\%))}{2} = 100\%$$

A_i - шатлалын үнэлгээ:

$A_i = \sum_1^5 \frac{A_i}{5} = 100\%$ **Зорилт 1-** 100% өөрөө үнэлэх; **Зорилт 2-** өөрөө 50%, удирдлага 50% үнэлнэ; **Зорилт 3-** өөрөө 50%, удирдлага 50% үнэлнэ; **Зорилт 4-** удирдлага 100% үнэлнэ.



ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

5.1 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- ❖ “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн удирдлага зохион байгуулалтыг Сургалт-оюутны асуудал эрхэлсэн дэд захирал хариуцна
- ❖ “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Багшийн хөгжлийн алба хариуцна
- ❖ Бүрэлдэхүүн сургуулийн захирал, салбар, тэнхмийн эрхлэгч нар Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ
- ❖ “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн гүйцэтгэлийн үзүүлэлтээр бүрэлдэхүүн сургуулиудын дунд рейтинг тогтоож, хянах үүргийг ШУТИС-ийн дэд захирлууд хариуцна
- ❖ “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх бодлого, зорилт, холбогдох дүрэм, журам, шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтыг Багшийн хөгжлийн албаны саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална

5.2 Хөтөлбөрийн санхүүжилт

- ❖ Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийн 7.3, 7.4 дүгээрт заасан эх үүсвэр
- ❖ Улсын төсвөөс багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж хуваарилсан хөрөнгийн эх үүсвэр
- ❖ ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулиудын багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж хуваарилсан хөрөнгийн эх үүсвэр
- ❖ Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч дотоод, гадаадын хандивлагч түншлэгчдээс олгосон санхүүжилт, сангийн хөрөнгө оруулалт
- ❖ Олон улсын хандивлагч байгууллага, их, дээд сургууль, байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд шийдвэрлэх хөрөнгийн эх үүсвэр
- ❖ Хууль тогтоомжоор хориглоогүй бусад санхүүжилтын эх үүсвэрүүд

Багшийн өөрийн хөгжлийн төлөвлөгөө

Батлав. Захирал.....

БАГШИЙН НЭР _____ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ _____

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ _____ САЛБАР, ТЭНХИМ _____

ЭРДМИЙН ЗЭРЭГ, ЦОЛ _____ АЛБАН ТУШААЛ-----

Багшийн чадамж		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Шаардагдах санхүү	Өөрийн үнэлгээ	Салбар, тэнхимийн үнэлгээ
Дэвшүүлсэн зорилт							
Багшлахуйн чадамж							
Судалгааны чадамж							
Англи хэлний чадамж							
Мэдээлэл, холбооны технологи ашиглах чадамж							
Мэргэжлийн чадамж							

Боловруулсан: _____ Багш _____ он/сар/өдөр

Хянасан: _____ Салбар, Тэнхимийн эрхлэгч _____ он/сар/өдөр

**БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Код	Хичээлийн сэдэв	Кредит цаг	Улирал
Багшлахуйн чадамж				
1	F.EP100	Боловсролын сэтгэл судлал	1	Намар
2	F.ET101	Боловсролын технологи	1	
3	F.LL102	Насан туршийн боловсролын онол, арга зүй	1	
4	F.TE103	Багшийн ёс зүй	1	
Судалгааны чадамж				
1	F.RE203	Судлаачийн ёс зүй	0,5	Намар
2	F.RM201	Судалгааны арга зүй	1	
3	F.IP202	Оюуны өмчийн эрх зүй	0,5	
4	F.AW203	Нийтлэл, өгүүлэл бичих арга зүй	1	
5	F.RP204	Төсөл, хөтөлбөр боловсруулах арга	1	
Англи хэлний чадамж				
1	F.FL200	Дунд шат	2	Намар, Хавар
2	F.FL201	Ахисан шат	2	
3	F.FL300	Шинжлэх ухааны англи хэл	2	
4	F.FL301	Мэргэжлийн англи хэл	2	
Мэдээлэл, холбооны технологи ашиглах чадамж			4	
1	F.IT205	МХХТ-д суурилсан сургалтын нээлттэй хэрэглэгдэхүүн бэлтгэх	1	Хавар
2	F.IT206	E-portfolio бэлтгэх	1	
3	F.IT207	МХХТ-ийг ашиглан олон улсын судалгааны төслүүдэд оролцох, зохицуулах	1	
4	F.IT208	Онлайн болон холимог хэлбэрийн сургалтын хөтөлбөр бэлтгэх, сургалтыг хөтлөн явуулах	1	
Мэргэжлийн чадамж			4	
1	F.PE303	Мэргэжлийн ёс зүй	0,5	Хавар
2	F.LM304	Манлайлал / менежмент	0,5	
3	F.PI305	Мэргэшсэн / зөвлөх инженер	2	
4	F.ST306	Бүтээлч сэтгэлгээ / инноваци	1	
<i>Нийт</i>			24	

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Багшийн хөгжлийг дэмжих хууль тогтоомж

2.1.Багшийн хөгжлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“багш” гэж Боловсролын тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээдийг;

3.1.2.“багшийн хөгжил” гэж багшийн мэдлэг, арга зүй, ур чадвар, боловсролоо дээшлүүлэх тасралтгүй үйл явцыг;

3.1.3.“багшийн хөгжлийн төв” гэж багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчинг;

3.1.4.“багшийн ажлын гүйцэтгэл” гэж суралцагчдын хөгжил, хүмүүжил, төлөвшил, хандлага, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан бусад чиг үүргийн хүрээнд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр илэрхийлэгдэх үр дүнг;

3.1.5.“ерөнхий боловсролын сургуулийн туслах багш” гэж багшийн мэргэжлээр төгссөн, сургалтын үйл ажиллагаанд багшид туслах үүрэг бүхий этгээдийг;

3.1.6.“боловсролын салбарын мэдээллийн систем” гэж бүх шатны боловсролын сургалтын байгууллага, сургалтын орчин, сургалтын үйл явц, үр дүн, салбарын хүний нөөц, суралцагчийн мэдээллийг бүртгэх, тайлан, мэдээ боловсруулах, хяналт тавих зориулалт бүхий программ хангамж, сүлжээний дэд бүтэц болон техник хангамжийн нэгдлийг.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хууль нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны албан болон албан бус боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багшид үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО

5 дугаар зүйл.Төрөөс багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо

5.1.Багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо нь багш бэлтгэх, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх, ажлын байран дээр тасралтгүй хөгжих үйл явцын нэгдэл байх бөгөөд багшид үндэсний, орон нутгийн, байгууллагын, сонирхлын бүлгийн, багшийн түвшинд дэмжлэг үзүүлнэ.

5.2.Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, байгууллагын түвшинд захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйч, сонирхлын бүлгийн түвшинд хамтын удирдлагын нэгдэл, багш өөрөө хэрэгжүүлнэ.

6 дугаар зүйл.Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр

6.1.Багшийн мэдлэг, боловсрол, хандлага, ёс зүй, эрүүл мэнд, нийгмийн баталгаа, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй байна.

6.2.Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

7 дугаар зүйл.Багшийн хөгжлийн төв

7.1.Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна.

7.2.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага нь бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.

7.3.Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна.

7.4.Дээд боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг тухайн сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна.

7.5.Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8 дугаар зүйл.Багшийг бэлтгэх

8.1.Орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн багшийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан захиалгаар багш бэлтгүүлэх гэрээг сургууль болон суралцагчтай байгуулж тэтгэлэг олгож болно.

8.2.Засгийн газар хоорондын гэрээтэй орнуудад тэтгэлгээр сургах хөтөлбөрүүдийн тэргүүлэх чиглэлд багшийн мэргэжлийг хамруулна.

8.3.Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

8.4.Ерөнхий боловсролын сургуулийн 44-өөс дээш хүүхэдтэй нэг, хоёрдугаар анги нь туслах багштай байж болно.

8.5.Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

9 дүгээр зүйл.Багшийн нийгмийн баталгаа, хөгжил, оролцоог дэмжих, хангах

9.1.Багш нь Төрийн албаны тухай хуулийн 61.1-д заасан төрийн албан хаагчийн болон Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан нийгмийн баталгаагаар хангагдана.

9.2.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт, боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох бөгөөд холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

9.3.Багш мэргэжлээр төгсөгчийн мэдээллийг төгсгөсөн сургууль нь боловсролын салбарын мэдээллийн системд илгээнэ.

9.4.Багшийг хөгжүүлэх үйл ажиллагаа нь багш мэргэжил эзэмшсэн хугацаанаас тооцогдох бөгөөд Боловсролын тухай хуулийн 40.8 дахь хэсэгт заасан багшийн мэргэжлийг дээшлүүлэх сургалтад хамрагдах үндэслэл болно.

9.5.Энэ хуулийн 9.4-г заасан хугацаанд багш сургалтад хамрагдаагүй тохиолдолд зардлыг өөрөө хариуцна.

10 дугаар зүйл.Багшийн оролцоо

10.1.Багш нь хувь хүний санаачилга, бүтээлч үйл ажиллагаанд суурилсан бие дааж хөгжих богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөтэй байна.

10.2.Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багш мэдлэг боловсрол, ур чадвараа сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагад санал, хүсэлт, гомдол гаргаж болно.

10.3.Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багш зорилго, санаачилгаар нэгдэн сонирхлын бүлэг байгуулж, хамтран ажиллаж болно.

10.4.Багш нь бүх шатны боловсролын сургалтын байгууллага, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөтэй хувийн болон сонирхлын бүлгийн хөгжлийн төлөвлөгөөг уялдуулна.

11 дүгээр зүйл.Багшийн ажлын үр дүн

11.1.Багшийн тухайн хичээлийн жилд ажилласан үр дүнгийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд боловсролын сургалтын байгууллага илгээнэ.

11.2.Багш хувийн хөгжлийн төлөвлөгөөндөө тусгасан ажлын гүйцэтгэлийг боловсролын салбарын мэдээллийн системд өөрөө илгээнэ.

11.3.Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЁС ЗҮЙ, НЭР ХҮНД

12 дугаар зүйл.Ёс зүйн хороо

12.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ их, дээд сургуулийн багшийн ёс зүйн хороотой байна.

12.2.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ мэргэжлийн боловсрол, сургалтын төвийн багшийн ёс зүйн хороотой байна.

12.3.Аймаг, нийслэлийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дэргэдээ ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн хороотой байна.

12.4.Бүх шатны боловсролын сургалтын байгууллага тухайн байгууллагын багш нарын төлөөлөл бүхий орон тооны бус ёс зүйн зөвлөлтэй байна.

13 дугаар зүйл.Ёс зүйн дүрэм

13.1.Багшийн ёс зүйн хорооны дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

13.2.Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын ёс зүйн дүрэмд дараах зүйлийг тусгасан байна:

13.2.1.багшийн эрхэмлэх зүйлс;

13.2.2.багшийн ёс зүйн хэм хэмжээ;

13.2.3.ёс зүйн хариуцлага.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

14 дүгээр зүйл.Засгийн газрын эрх, үүрэг

14.1.Засгийн газар дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1.багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 5 жил тутам батлах;

14.1.2.багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгаж, хэрэгжүүлэх;

14.1.3.хууль тогтоомжид заасан бусад.

15 дугаар зүйл.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг

15.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага багшийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1.багшийг хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.2.багшийг түрээсийн орон сууц, ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр хамруулах хөтөлбөрийг барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

15.1.3.боловсролын салбарын мэдээллийн цахим санг бүрдүүлэх;

15.1.4.хуульд заасан бусад.

16 дугаар зүйл.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллагын эрх, үүрэг

16.1.Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт-арга зүйн байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1.багшийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг жил бүр боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулах;

16.1.2.бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багшийн хөгжлийн төвд мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

16.1.3.багшийн хөгжлийн асуудлаар тогтмол судалгаа явуулах.

16.2.Багш мэргэжлээр их, дээд сургууль төгсөөгүй дээд боловсролтой төгсөгчид багшлах эрх олгох, сунгах шалгалтыг зохион байгуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ

17 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

18.1.Энэ хуулийг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

